



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/372

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу "Тулга констракшн" ХХК-ий эзэмшлийн Хэрлэн сумын 3 дүгээр баг (Баянмөнх), Үндсэн хуулийн гудамж К-30 тоотод байршилтай орон сууцны зориулалттай 6105 м<sup>2</sup> газрыг "Оршихуйн анир" ХХК-д 15 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.


2. "Оршихуйн анир" ХХК-ий эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Оршихуйн анир" ХХК-ий захирал (Ц.Оюунбат)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/254 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



ЦИДЭРБАТ

231011842